



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны 12 сарын 12 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 12 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 12.4, 12.5 дахь хэсэг нэмсүгэй:

"12.4. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын гаргасан урьдчилсан мэдээ, статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын энэ хуулийн 6.1-д заасан хугацаанаас өмнө гаргасан статистикийн мэдээллийг үндэслэн даатгагч энэ хуулийн 4.1.8-д заасан гэрээний хугацаанд нөхөн төлбөрийг нэг удаа урьдчилан олгож болно.

12.5. Энэ хуулийн 12.4-т заасан нөхөн төлбөрийг энэ хуулийн 26.2-т заасан журмын дагуу олгоно."

2 дугаар зүйл. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалт:

"4.1.9. "давхар даатгалын компани" гэж энэ хуулийн 18.1-д заасан давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэн явуулах, тусгайлсан чиг үүрэг бүхий хуулийн этгээдийг;"

2/12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг:

"12.2. Даатгагч нөхөн төлбөрийг энэ хуулийн 12.4-т зааснаас бусад тохиолдолд хэсэгчлэн олгохыг хориглоно."

3 дугаар зүйл. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн "зургаан" гэснийг "таван" гэж, 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийн "03 дугаар сарын 01-ний" гэснийг "04 дүгээр сарын 01-ний" гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн "малын" гэснийг хассугай.

5 дугаар зүйл. Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Н.УЧРАЛ